



Ерөнхийлөгч
Рассэл
М.Нэлсон

Чи хэрхэн номлогч байж чадах вэ?

Их Эзэн шавь нартаа “Бүх ертөнцөөр явж, сайн мэдээг хамаг бүтээлд тунхаглагтун” (Марк 16:15) хэмээн зарлигласан билээ. Хүн бүр Есүс Христийн найдвар, амар амгаланг хаанаас олж болохыг мэдэх эрхтэй. Бид сонсох бүх хүнтэй Есүс Христийн амар амгаланг хуваалцах ариун нандин үүрэг хүлээдэг.



Чи бусдад сайн мэдээний амар амгаланг олоход нь дараах байдлаар тусалж чадна.



Сайн үлгэр жишээ үзүүл.



Есүс Христийг дагаснаар Түүний гэрэл нүднээс чинь гэрэлтэх болно.



Найз нөхдийн хүрээгээ тэл.



Найзыгаа Мормоны Ном уншихад урь.



Найзыгаа Сүмийн цуглаан эсвэл үйл ажиллагаанд оролцоход урь.

Мөн чи насанд хүрмэгцээ номлолд үйлчлэхээр шийдэж болно. Энэ нь чамайг болон бусад олон хүнийг адислах болно.

“Амар амгалангийн сайн мэдээг номлох нь”, Лиахона, 2022 оны 5-р сар, 6–7; мөн “Итгэгч хүмүүсийн үлгэр дуурайл бай”, Лиахона, 2010 оны 11-р сар, 49–53-аас авч ашиглав.

Найзуудын тойрог

Зургаас Хүүхдийн хэсгийн үйл ажиллагаанд оролцож буй хэдэн хүүхдэд доорх зүйлс байгааг хай.

Хар үс
Шар цамц
Сүлжсэн үс

Нүдний шил
Ногоон үүргэвч

Улаан гутал
Тэргэнцэр

Хөл бөмбөгийн бөмбөг



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ГАРТ БРҮНЭР